

Австри улсад хүүхэд асрагчаар ажиллах

Суурьшигч, оршин суугчдын тухай шинэ хуулинд өөрчлөлт орсноор (2006 оны 01-р сарын 01-нээс хүчин төгөлдөр болсон) оршин суух зөвшөөрөл олгох асуудлыг Австри улсын албан байгууллагууд (улс болон мужийн засаг захиргааны байгууллагууд) хариуцах болсон. Монголоос виз мэдүүлэгчид нь өргөдлөө Бээжин дэх Австрийн Элчин сайдын яаманд өгнө. Өргөдлийг өөрийн биеэр авчирч өгөх бөгөөд шуудангаар ирүүлсэн өргөдлийг хүлээн авах боломжгүй. Виз мэдүүлэгч нь насанд хүрээгүй бол өргөдлийг түүний хууль ёсны төлөөлөгч өгнө. Бүх баримт бичгийг **хоёр хувь бүрдүүлж** өгнө (эх хувь, хуулбар).

18-28 настай гадаадын иргэнийг 12 хүртэлх сарын хугацаагаар австри айлд хүүхэд асрагчаар ажиллуулж болно. Герман хэл мэддэгээ нотлох ёстой.

Бүрдүүлж өгөх материал:

- “Бие даасан бус байдлаар хөдөлмөр эрхлэх онцгой тохиолдлууд” маягтыг бөглөн гарын үсгээ зурж өгнө.
(Маягтыг (http://www.bmi.gv.at/niederlassung/formulare_antraege.asp хаягаар татан авч болно).
- Хамгийн сүүлд авхуулсан паспортын зураг 2 хувь (3,5 x 4,5-с 4,0 x 5,0 см-ийн харьцаатай)
- Хүчинтэй аялалын паспорт (хоёр хуулбарын хамт)
- Төрсний гэрчилгээ (орчуулсан, баталгаажуулсан, давхар баталгаажуулсан, эх хувиар, нотариатын гэрчилгээ)
- Ял шийтгэл хүлээж байсан эсэх тухай цагдаагийн байгууллагын тодорхойлолт (орчуулсан, баталгаажуулсан, давхар баталгаажуулсан, эх хувиар, нотариатын гэрчилгээ), 3-аас дээшгүй сарын өмнө олгосон
- Хөдөлмөрийн зах зээлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын зохих мэдэгдлийг авсны талаарх тодорхойлолт
- Дараах заалтуудыг тусгасан хүүхэд асрагчийн гэрээ:
 - а) Байр, хоолоор хангах (байрлах байрны тодорхой хаяг, хоол)
 - б) Долоо хоног бүр халаасны мөнгө өгөх (долоо хоногт 60-70 орчим Евро),
 - в) Герман хэлний курст суралцах боломж олгож, төлбөрийн хагасыг хүлээн авсан айл хариуцах (сард 50 орчим Евро),

- г) Хүүхэд асрагчийг хүлээн авсан айлын зардлаар даатгал (эрүүл мэндийн даатгал, гэнэтийн ослын даатгал)-д бүрэн хамруулах (Сард 175 орчим Евро),
- Герман хэлний үндсэн мэдлэг эзэмшсэнийг нотлох нотолгоо (Жишээ нь хэлний институтэд курст суралцсан тухай тодорхойлолт).

Тайлбар: нотариатчийн баталгаажуулсан бүх баримтыг тухайн улсын Гадаад харилцааны яам (Хятад буюу Монгол улсын)-аар давхар баталгаажуулна. Дараа нь Австри улсын Элчин сайдын яамаар дахин баталгаажуулах боломжтой (баталгаажуулах материал бүрт 30 Евро).